

ШИЛЭН ДАНСНЫ ХУУЛИЙН ХЭРЭГЖИЛТЭД
ДОТООД АУДИТ ХИЙСЭН ТАЙЛАН
/2022 ОНЫ 4 ДҮГЭЭР УЛИРАЛ/

2023.01.24

Дархан-Уул аймаг

Нэг. Эрх зүйн үндэслэл, зорилго

Монгол Улсын Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журмын 8 дугаар зүйлийн 8.2, 8.5 дахь заалт, аймгийн Засаг даргын баталсан Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2023 онд хийх хяналт шалгалтын төлөвлөгөө, аймгийн Засаг даргын Шилэн дансны хуулийг хэрэгжүүлэх тухай 2022 оны 01-04/02 дугаар албан даалгаврыг тус тус үндэслэн шилэн дансны үйл ажиллагаанд дотоод аудитын шалгалт хийж, дүгнэлт өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг арилгуулах, цаашид үүсэх эрсдлээс урьдчилан сэргийлж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөхөд оршино.

Хоёр. Хамрах хугацаа, цар хүрээ

2022 оны 4 дүгээр улирлын байдлаар аймаг, сумын 5 Төсвийн Ерөнхийлөн захирагч, орон нутгийн төсвийн 99 байгууллага, төрийн өмчийн 37 байгууллагын шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын 2 дугаар зүйлд заасан мэдээллийг хугацаандаа үнэн зөв бүрэн мэдээлсэн эсэх, тайлан илгээлт, хэрэглэгчдийн хувийн мэдээлэл шинэчлэгдсэн эсэх асуудлууд дотоод аудитад хамрагдсан.

Санхүүгийн хяналт дотоод аудитын албанаас дээрх байгууллагын удирдлага, нягтлан бодогч нарт шилэн дансны мэдээллийг цаг хугацаанд нь бүрэн гүйцэт, үнэн зөв мэдээлэх талаар 4-5 удаа анхааруулж зөвлөмж өгч ажиллалаа.

Гурав. Үр дүн

Байгууллагуудын шилэн дансанд байршуулсан мэдээллийг төрийн сангийн дансны хуулга, тухайн тайлант хугацаанд гарсан төсвийн өөрчлөлт, тухайн мэдээлэл тавих албан тушаалтны өөрчлөлт зэрэгт тулгуурлан шалгалаа.

3.1 Төсвийн Ерөнхийлөн захирагч болон түүний хамрах хүрээний байгууллагууд

Аймаг, сумдын нийт 5 төсвийн ерөнхийлөн захирагчийн Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100 хувьтай байх ба нийт 878 мэдээлэл байршуулахаас 96 хувь буюу 842 мэдээллийг хуулийн хугацаанд, 4 хувь 36 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Дархан-Уул аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн хамрах хүрээний 99 байгууллага Шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байх ба хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна. Нийт 16,210 мэдээлэл байршуулахаас 96,8 хувь буюу 15,692 мэдээллийг хуулийн хугацаанд, 3,2 хувь буюу 518 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэжээ. Мөн 4 дүгээр улирлын тайланг бүрэн илгээсэн байна.

3.2 Төрийн өмчит байгууллагууд

Дархан-Уул аймгийн хэмжээнд төрийн өмчит 37 байгууллага Шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байх ба хуулийн хэрэгжилт 100 хувьтай байна. Нийт 6,162 мэдээлэл байршуулахаас 94,5 хувь буюу 5,825 мэдээллийг хуулийн хугацаанд, 5,5 хувь буюу 337 мэдээллийг хугацаа хоцроож мэдээллэсэн байна.

Санхүүгийн хяналт, дотоод аутидын алба нь төрийн өмчит байгууллагуудын улирлын тайлан илгээсэн байдлыг хянах эрх байхгүй тул дотоод хяналтыг хийгээгүй болно.

Дөрөв. Шалгалтаар илэрсэн зөрчил дутагдал

4.1 2022 оны 3 дугаар улирлаас шилэн дансны мэдээллийг шинээр 2 байгууллага, давтан хугацаа хоцроосон 15 байгууллага байна.

4.2 2022 оны 4 дүгээр улирлын байдлаар 12 байгууллага нийт 48,208,674 төгрөгийн зарлагын, 933,561,028 төгрөгийн орлогын гүйлгээ бүхий цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг Шилэн дансны цахим хуудсанд мэдээллээгүй байна.

4.3 Дархан-Уул аймгийн хэмжээнд 58 аж ахуй нэгж байгууллага, төсвөөс татаас авдаг хувийн сургууль, цэцэрлэг Шилэн дансны цахим хуудсанд бүртгэлтэй байх ба Улс орон нутгийн төсвийн хөрөнгөөр 10 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий ажил, үйлчилгээ гүйцэтгэсэн талаарх улирлын мэдээллийг 42 байгууллага хуулийн хугацаанд, 16 байгууллага огт мэдээллээгүй байна.

Тав. Дүгнэлт

5.1 Аймгийн хэмжээнд 4 дүгээр улирлын байдлаар 22,359 мэдээллийг хуулийн хугацаанд, 891 мэдээллийг хугацаа хоцроон, нийт 23,250 мэдээллийг оруулж Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт 100%-тай байна.

Зургаа. Цаашид авах арга хэмжээний санал

6.1 Төсвийн захирагч нар Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шуурхай хангаж, шилэн дансны цахим хуудсанд байршуулах мэдээллийг стандартын дагуу, үнэн зөв, бодитой, иж бүрэн, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлж, хэрэгжилтэд тавих хяналтыг тогтмол, бодитой тавьж ажиллахыг анхааруулах зөвлөгөөг цахим хуудас болон фэйсбүүк группээр мэдээлэл өгөх;

6.2 Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийг хугацаа хоцроон мэдээлсэн Ахмадын хөгжлийн төв, МЭДСТОБ ӨЭМТ, Нийгмийн даатгалын сан, Дархан төмөрлөг ТӨХК, Дархан өргөө политехник коллежи, Прокурорын газарт Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас зөвлөмж өгөх;

6.3 Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн хуулийн хугацааг мөрдөлгүй 3 улиралд зөвлөмж авсан болон дахин давтан хугацаа хоцроосон Орхон сумын ТЕЗ, Дархан сумын 31 дүгээр цэцэрлэг, Орхон соёлын төв, Хөдөө аж ахуй техник дундын төв ОНӨААТҮГ, Дархан хотын соёл амралтын хүрээлэн ОНӨААТҮГ, УУЭХПКоллежид Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас улсын ахлах байцаагчийн албан шаардлага хүргүүлэх;

6.4 Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн хуулийн хугацааг мөрдөлгүй 3 улиралд албан шаардлага, хариуцлага тооцох санал хүргэгдсэн болон дахин давтан хугацаа хоцроосон Залуучууд театр, УГТЭШХүрээлэн, Жижиг дунд үйлдвэрийг дэмжих төвд дахин хариуцлага тооцох саналыг ТЕЗ-д хүргэх;

6.5 Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний мэдээллийг оруулаагүй 12 байгууллагад Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.5 болон Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журмын 3.2.10-т заасны дагуу мэдээлж байх тухай зөвлөмж өгөх.

ТАЙЛАН ХЯНАСАН:

ДАРГА

Л.ДАГИЙСҮРЭН

ТАЙЛАН БИЧСЭН:

ДОТООД АУДИТОР

А.САНДАГДОРЖ